

## ЖУРМЫН ТӨСӨЛ ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

### БАНКНЫ МӨНГӨ УГААХ ,ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх/цаашид МУТС гэх/-тэй тэмцэх тухай хууль, Засгийн газрын тогтоол, тэдгээртэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд зайнаас хяналт тавих, банкны МУТС-тэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж газар дээрх хяналт шалгалтын чиглэл, хамрах хугацаа, давтамжийг тодорхойлоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Зайнаас тавих хяналтын хүрээнд дараах ажлууд хийгдэнэ:

1.2.1 банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар тодорхой давтамжтайгаар тайлан, мэдээ гаргуулан авч дүгнэлт хийх, биелэлтийг хангуулах;

1.2.2 Банкны бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээний талаар энэ журамд заасан тайлан, мэдээлэл дээр үндэслэн банкны МУТС тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг үнэлж, газар дээрх хяналт шалгалтын чиглэл, хамрах хугацаа, давтамжийг тодорхойлох;

1.2.3 хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор банкны авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг нь хангуулах, банк, түүний удирдлагад хууль тогтоомжид заасан хариуцлага тооцох талаар санал, дүгнэлт боловсруулах.

#### ХОЁР. ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТАД АШИГЛАХ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

2.1 Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавихад дараах тайлан мэдээг ашиглана:

2.1.1 банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны “Эрсдэлийн үнэлгээний матриц”/Энэ журмын хавсралт 1/;

2.1.2 эрсдэлийн үнэлгээний матриц-д ашиглах “Тоон өгөгдлийг цуглуулах маягт”/Энэ журмын хавсралт 2/;

2.1.3 банкны МУТС-тэй тэмцэх “Хяналтын тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга” /Энэ журмын хавсралт 3/;

2.1.4 газар дээрх хяналт шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайлан;

2.1.5 банкны ТУЗ-д танилцуулсан МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны улирлын тайлангийн хувь;

2.1.6 банкнаас ирүүлсэн бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан, сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо, тайлангийн чанар/хууль заасан хугацаанд мэдээлж байгаа эсэх, тайланд агуулагдах мэдээлэл бүрэн эсэх/, асуулга, лавлагаанд хариулж хамтран ажиллаж байгаа байдлын талаар Санхүүгийн мэдээллийн албаны /цаашид СМА гэх/ дүгнэлт;

2.1.7 банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх эсхүл хоёрдогч өглөг хэлбэрээр хөрөнгө татаж байгаа тохиолдолд тухайн хөрөнгийн гарал үүслийн талаар банкнаас ирүүлсэн баримт, материал;

2.1.8 банкны хувь нийлүүлэгч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй ажиллах этгээдийн талаарх тодорхойлолт, анкет, лавлагаа болон бусад нэмэлт мэдээлэл;

2.1.9 Банкны тухай хуулийн 6.3-д заасан мэдээлэл болон шинээр нэвтрүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс үүдэн гарах МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг банк хэрхэн үнэлэх, удирдах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

2.1.10 Монголбанкны хянан шалгагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан бусад баримт, мэдээлэл;

2.1.11 хянан шалгагчийн банкны удирдлагатай ярилцлага хийх, тайлбар авах хэлбэрээр гаргуулан авсан нэмэлт мэдээлэл, тодруулга.

## ГУРАВ. ТАЙЛАН МЭДЭЭЛЛИЙН ХУГАЦАА, ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Энэ журмын 2.1.4, 2.1.5 болон 2.1.6-д заасан тайлан, дүгнэлтийг улирал тутам, 2.1.7, 2.1.8 болон 2.1.9-д заасан баримт, мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр нь, 2.1.10, болон 2.1.11-д заасан мэдээллийг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гаргуулан авна.

3.2 Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас тавих хяналт байнга, тасралтгүй хийгдэхийн зэрэгцээ энэ журмын 2.1.2 -д заасан тоон мэдээллийг, 6 сар тутамд, 2.1.3-д заасан асуулгын 12 сар тутамд нэг удаа цуглуулна. 2.1.1-д дурдсан эрсдэлийн

үнэлгээний матрицын дагуу банкны МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг хийнэ.

3.3 Хянан шалгагч нь тайлан, мэдээллийг банкны удирдлага баталгаажуулан, батлагдсан маягт, зааврын дагуу хугацаанд нь бүрэн ирүүлсэн эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.4 Хянан шалгагч нь банкнаас ирүүлсэн тайлан, баримт, мэдээллийг, холбогдох журмын дагуу бичиг хэргийн бүртгэлд бүртгүүлж, материалыг банкны хувийн хэрэгт хавсарган, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.5 Энэ журмын хавсралт-1 “Эрсдэлийн үнэлгээний матриц”-ийн тооцоололд ашиглах харьцаа, хувийн жин, Хавсралт-2 “Тоон өгөгдлийг цуглуулах маягт” болон Хавсралт-3 “Хяналтын тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх асуулга”-ын оновчтой, үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавиж ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурлын шийдвэрээр өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлтийг бүх банкны эрсдэлийн үнэлгээнд нэгэн ижил ашиглана.

## ДӨРӨВ. ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ДҮГНЭЛТ

4.1 Банкны МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас тавих хяналт байнга, тасралтгүй хийгдэхийн зэрэгцээ 6 тутамд нэг удаа зайнаас тавих хяналтын дүгнэлт гаргаж Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлд танилцуулна.

4.2 Зайнаас тавих хяналтын дүгнэлтэд дараах зүйлсийг тусгана:

4.2.1 энэ журмын 2.1.2 болон 2.1.3-д заасан тоон мэдээлэл, асуулгыг ашиглан 2.1.1-д дурдсан эрсдэлийн үнэлгээний матрицын дагуу банкны МУТС эрсдэлд хийсэн үнэлгээг;

4.2.2 банкны МУТС эрсдэлийн үнэлгээнд гарсан өөрчлөлт, түүний шалгаан, эрсдэлийг өсгөж байгаа гол хүчин зүйлс;

4.2.3 банкны МУТС-тэй тэмцэх бодлого, журмын дутагдалтай, сул талууд;

4.2.4 банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийг бууруулах чиглэлээр өмнө нь авсан арга хэмжээ, өгсөн үүрэг даалгавар тэдгээрийн хэрэгжилт;

4.2.5 хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, МУТС эрсдэлийг бууруулах зорилгоор банкинд цаашид хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөөний санал;

4.2.6 банкинд хийх газар дээрх хяналт шалгалтын чиглэл, хамрах хугацаа, давтамжийн талаарх санал;

4.2.7 банк, түүний удирдлагад хариуцлага ногдуулах талаар санал, дүгнэлт.

4.3 Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийгдэх бүрт банкны эрсдэлийн үнэлгээ, зайнаас тавих хяналтын дүгнэлтийг газар дээрх шалгалтын акт материалтай нийцүүлэн шаардлагатай өөрчлөлтийг хийнэ.

#### ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү журмыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.